



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 08 сарын 09 өдөр

Дугаар А/75

Арвайхээр

Байгууллагын дүрэм, бүтэц, орон тооны
дээд хязгаарыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хархорин сумын Спортын ордны дүрмийг шинэчлэн нэгдүгээр хавсралтаар, бүтэц, орон тоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан дүрэм, бүтэц, орон тоог мөрдөж ажиллахыг Хархорин сумын Спортын ордон (Б.Батдорж)-д үүрэг болгосугай.

3.Байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр ханган ажиллахыг Хархорин сумын Засаг дарга (Ч.Алтанбагана)-д даалгасугай.

4.Хавсралтад заасан орон тооны дагуу санхүүжилт олгож, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

5.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны “Дүрэм батлах тухай” а/511, аймгийн Засаг даргын 2019 оны “Байгууллагын орон тооны дээд хязгаарыг батлах тухай” А/343 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100159

Аймгийн Засаг даргын 2021 оны 09
дугаар сарын 09 ны өдрийн 48 дүгээр
захирамжийн хоёрдугаар хавсралт

ХАРХОРИН СУМЫН СПОРТЫН ОРДНЫ БҮТЭЦ, ОРОН ТОО

№	Бүтэц	Орон тоо
1.	Дарга	1
2.	Арга зүйч	1
3.	Дасгалжуулагч	2
4.	Нягтлан бодогч	1
5.	Жижүүр	4
6.	үйлчлэгч	3
	Нийт	12

-oOo-